



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 28-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.11.06 № 28

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны
биелэлтийн талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулахаар ажиллаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны улсын хэмжээний гүйцэтгэх баримт бичгийн гүйцэтгэвэл зохих тоо, мөнгөн дүн, гүйцэтгэсэн баримт бичгийн тоо, мөнгөн дүн, хувь, гүйцэтгээгүй баримт бичгийн тоо, мөнгөн дүн, хувийг ангилал (иргэн, эрүү, захиргаа, зөрчил, хүүхдийн тэтгэлэг ...) бүрээр сүүлийн 10 жилийн байдлаар гаргаж ирүүлнэ үү.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.НОМИНЧИМЭГ